

Аудитаар анхаарах асуудал

*Аймгийн Аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.БОЛОРТУУЛ*

Чойбалсан хот 2017.03.07

Санхүүгийн тайлангийн аудит

- Төсвийн хуульд заасан богино хугацаанд хязгаарлагдмал нөөцөөр орон нутгийн хэмжээн дэх төсвийн болон орон нутгийн, төрийн өмчит байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулан, аудитын дүгнэлт өгөх шаардлага тулгардаг.
- Хуулиар хүлээсэн дээрх шаардлагыг илүү үр нөлөөтэй биелүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитыг улсын хэмжээнд богино хугацаанд нэгтгэж, удирдах, зохион байгуулах шаардлага зүй ёсоор урган гарсан.
- Санхүүгийн тайлангийн аудит хийх стандартчлагдсан арга зүйг боловсруулах, хөгжүүлэх, аудитад нэвтрүүлэх ажлыг “Смарт грийн технологи” ХХК-тай хамтран цахим хэлбэрт шилжүүлэн Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС)-ээр аудитыг цахим хэлбэрээр хийн, хянан, улсын хэмжээнд нэгтгэдэг болсон.

Санхүүгийн тайлангийн аудит гэж...

Байгууллагын санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулахыг хэлнэ

Батламж мэдэгдэл

- 1. Оршин байх:**
- 2. Эрх ба үүрэг:**
- 3. Тохиолдсон байх:**
- 4. Иж бүрэн байх:**
- 5. Үнэлгээ:**
- 6. Хэмжилт:**
- 7. Толилуулга ба тодруулга:**
- 8. Үнэн зөв байдал:**

Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, дотоод хяналт сайтай нь тогтоогдож 3 жил дараалан зөрчилгүй дүгнэлт авсан.
2. Тухайн санхүүгийн жилийн зохих хугацаанд завсрын аудит хийгдсэн.
3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж биелэлтийг ирүүлсэн.
4. Төсвийн тухай, Шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийг мөрдөж ажилласан.
5. Сүүлийн 3 жилд улсын болон орон нутгийн төсвийг хэмнэж, зориулалтын дагуу зарцуулсан, төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл багатай.
6. Тайлант хугацаанд бүтэц, зохон байгуулалтын өөрчлөлт ороогүй.
7. Байгууллагын удирдлага болон ерөнхий /ахлах/ нягтлан бодогч тогтвор суурьшилтай ажилласан.
8. НББ-ийн бодлогын баримт бичиг болон санхүү, бүртгэлийн програм хангамжид өөрчлөлт ороогүй.
9. Санхүүгийн тайлан болон бусад аудит хийгдснээс хойш хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүмжлэлд өртөөгүй.
10. Олон нийтийн болон хууль тогтоох байгууллагын анхаарал татсан бусад асуудал хөндөгдөөгүй.

Завсрын аудит ...

Завсрын аудит гэж тайлант жилийн явцад нэг буюу хэдэн улирлын санхүүгийн тайланд хийх аудитыг ХЭЛНЭ

Төрийн аудитын тухай хууль түүнээс үүдэн гарсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9-д заасны дагуу 110 байгууллагад завсрын аудитыг хийсэн.

Төрийн аудитын тухай хуулинд...

Монгол Улсын Төрийн Аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Засгийн газар болон бусад байгууллагууд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргаж Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”

Төсвийн тухай хуулинд ...

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “Төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ...”

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИНД ...

9.4-д “Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайланг тайлагнаж, тушаана”.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИНД ...

8.2-д “Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана”.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИНД ...

14.2-д “Аж ахуйн нэгж,
байгууллага нягтлан бодох
бүртгэлээ давхар бичилтийн
аргаар хөтөлнө”.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИНД ...

3.1.2-д. “давхар бичилт” гэж ажил, гүйлгээг дансны дебет, кредитэд зэрэг бичилт хийхийг;


Нийтлэг гаргадаг алдаа зөрчил...

- Бараа материалын үлдэгдлийг эд хариуцагчтай тооцоо нийлж баталгаажуулалгүйгээр тусгах.
- Эд хариуцагчаар бараа материалын тайланг батлагдсан маягт, зааврын дагуу гаргуулан авалгүй санхүүгийн тайлан, балансыг илэрхийлэх.
- Бараа материалын дансны бичилт хийхдээ тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичих.
- Олгосон цалингийн урьдчилгааг суутган тооцохгүй шууд зардалд бичих.


Нийтлэг гаргадаг алдаа зөрчил...

- Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулалгүй тусгах.
- Хөрөнгийн тооллого, тооцоо хийлгүй жилийн эцсийн хөрөнгийн тайлан, баланс гаргах.
- Засгийн газрын сан дансыг нэмэгдүүлэн бичих.
- Зарцуулагдаагүй зардлын үлдэгдлийг харилцагч байгууллагад шилжүүлэн авлагаар тусгахгүй байх.

Аудитаар илэрсэн зөрчлийг графикаар харуулав. /2014-2015 оны тэрбум төгрөгөөр/



Аудитаар илэрсэн зөрчлийг графикаар харуулав. /2016-2017 оны тэрбум төгрөгөөр/



Хариуцлага тооцуулах санал

- Төрийн Аудитын тухай хуульд заасны дагуу хуулийн хугацаа хоцроон ирүүлсэн орон нутгийн төсөвт 114 байгууллагын удирдлагуудад хариуцлага тооцуулах саналыг хүргүүлээд байна.

Дүгнэлт:

- Төсвийн шууд захирагч нар санхүүгийн тайлангаа Монгол Улсын Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлэхгүй байгаа шалтгааныг авч үзэхэд бүтэц орон тооны өөрчлөлт, шинэ томилгоо, удирдах ажилтны хуулийн мэдлэг дутмаг, нягтлан бодогч нар хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ЕМ нарыг мэргэжил, арга зүйгээр хангахгүй, хайхрамжгүй байдлаас үүдэлтэй гэж үзэж байна.

Цаашид...

Төрийн аудитын байгууллагаас 2017 онд
**“Боловсролын байгууллагын удирдлага, зохион
байгуулалт, менежментийн арга хандлага”** гэсэн
сэдвээр ГА-ыг хийнэ.

***АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА
БҮХЭНД БАЯРЛАЛАА.***